



УВС АЙМАГ  
ХЯРГАС СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 1/01

Дэлгэр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 47.1, 47.2, 47.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.1, 16.5.2, Бага дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, бага ангийн сурагчдын үдийн хоолны хэрэгцээнд хүнсний материал нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолт, тендерийн урилга, баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэх, тендерийг хянаж үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрхийг захиалагчид олгох үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ш.Доржпалам /Нийгмийн ажилтан/

Нарийн бичиг: А.Цэцэгмаа /Нярав/


Гишүүд: Б.Оюунчимэг /Санхүү албаны дарга/

Ц.Эрдэнэчимэг /Нягтлан бодогч/

М.Алтанхуяг /Эмч/

2. Тендерийн ажлыг чанартай зохион байгуулж, холбогдох баримт бичгийг \_\_\_\_\_охих журмын дагуу бүрдүүлэхийг үнэлгээний хорооны дарга /Ш.Доржпалам/-д \_\_\_\_\_аалгасугай.

ЗАХИРАЛ



Х.ЦОГТБАЯР